



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 11 сарын 29 өдөр

Дугаар А/А99

Булган сум

Мөсөн дээгүүр хөдөлгөөн хийхийг хориглох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Авто тээврийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Булган аймгийн нутаг дэвсгэр дэх гол, мөрөн, нуур, цөөрмийн мөсний зузаан Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн 2023 оны 11 дүгээр сарын 28-ны 01/157 дугаар дүгнэлтээр том голуудын эрэг дагуух мөсний зузаан 20-35 см, жижиг голуудынх 6-13 см байгаа нь эгц эрэг үүсэн машин орох боломжгүй, мөс цөмрөх эрсдэлтэй байгаа тул 2023 оны 11 дүгээр сарын 28-ны өдрөөс 2024 оны 05 дугаар сарын 15-ны өдөр хүртэл хугацаанд мөсөн дээгүүр хөдөлгөөн хийхийг хориглосугай.

2. Сумын нутаг дэвсгэрт орших гол, мөрөн, нуур, цөөрмийн мөсөн дээгүүр явганаар, бүх төрлийн тээврийн хэрэгсэл, ердийн хөсгөөр явах болон мал туух зэрэг хөдөлгөөн хийхийг хориглох, анхааруулах тэмдэг, тэмдэглэгээ байрлуулах, мөс цөмрөх аюулаас урьдчилан сэргийлэх мэдээ, мэдээллийг иргэд, олон нийтэд хүргэх, гарам бүхий газрын ойролцоо амьдардаг малчин өрхүүдээр хөдөлгөөнт хяналт тавиулах ажлыг зохион байгуулахыг сумын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Мөсөнд цөмрөх аюулаас урьдчилан сэргийлэх ажлыг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр олон нийтэд түгээхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хэвлэл, мэдээлэл, олон нийттэй харилцах алба (Г.Алтанцэцэг)-д даалгасугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Цагдаагийн газар (Цагдаагийн дэд хурандаа Г.Ганбаяр), Авто тээврийн төв (Н.Баасанжаргал) сумын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА  БАРИУН-ЭРДЭНЭ

Сугар Ажил 2023 өдөр бүр Doc/2023/Захирамж

0303010940